



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

171 /171/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.04

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ДЭГ ЖУРАМ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ УЛАМ БЭХЖҮҮЛНЭ

Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн өргөтгөсөн хурал боллоо. Энэхүү хуралд яамны харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, ЗХЖШ, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалууд, ЗХЖШ-ын Хяналт шалгалт, үнэлгээний газар, Барилга инженерийн цэргийн удирдах газрын удирдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүн цахимаар оролцсон юм.



Хурлын үеэр ЗХЖШ болон ҮБХИС-ийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний зарим анги, байгууллагуудад ажилласан дүнгийн талаар мэдээлэл хийснээс гадна Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх

зөвлөлийн дарга Б.Баярмагнай хуралдаанд оролцогчдод тус тусын байгууллагадаа аливаа гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх талаар дорвитой ажил зохион

байгуулах талаар зарим үүрэг, чиглэлийг өглөө.

1938 он.

Цэргийн яамны ажиллах журмыг чангатгах тухай Ардын хувьсгалт цэргийн Жанжин штабын даргын 15 тоот тушаал гарч, Цэргийн яам ба Жанжин штабын газар, хэлтсүүд нь өдөр тутам 9-12 цаг хүртэл гаднаас ирэх хүмүүсийг хүлээн авахгүй, зөвхөн өөрийн төлөвлөгөөт дотоод ажлыг хийх, 12-14 цаг хүртэл гаднаас ирэгсдийг хүлээн авч уулзах, 14-15 цаг хүртэл гаднаас ирэгсдээс хүлээн авсан зүйлүүдэд шийдвэр хариуг гаргаж өгөхөөр шийдвэрлэжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-3	-13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,850.0	2,853.0
EUR	3,305.0	3,315.0
CNY	444.50	446.00
RUB	40.00	41.20
JPY	25.00	25.20
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ

2021.11.04 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 29/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН УЛААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.41-17.30

Бариуллага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Ус

Аргын тооллын 11 сарын 4, Бархасвад гараг. Билгийн тооллын 30, Салхины эх одтой, улаан луу өдөр. Өдрийн наран 7 цаг 41 минутад мандан, 17 цаг 30 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түгэн бүтээх, бүтээл туурвих эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

УУЛЗАЛТ

ХУРАНДАА ӨЗГҮР НАЗЫМ УНСАЛЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



байсан туршлагатайг онцолж, цаашид зохион байгуулагдах сургууль, дадлагуудад Монгол Улсын Зэвсэгт хүчин оролцоогоо үргэлжлүүлэхийг эрмэлзэнэ гэдгийг мэдэгдлээ.

Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа Өзгүр Назым Унсал хурандаа С.Ганбямбад шинэ албан тушаалд томилогдсонд нь баяр хүргэж, БНТУ-ын цэргийн сургуулиудад бэлтгэгдсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнээс ЗХЖШ-ын удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байгаад

баяртай байгаагаа илэрхийллээ.

Мөн БНТУ-ын зохион байгуулдаг олон улсын цэргийн сургууль, дадлагад монгол цэргүүдийн оролцож байгааг харах нь нэр төрийн хэрэг байдаг гэдгийг хурандаа Өзгүр Назым Унсал онцолж, Монгол Улсад жил бүр зохион байгуулагддаг "Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд БНТУ-ын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн үргэлжлүүлэн оролцоно гэв.

Ахмад Б.ЗОЛЖАРГАЛ



ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, хурандаа Өзгүр Назым Унсалыг хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд хурандаа С.Ганбямба Монгол Улс 1999 онд БНТУ-тай батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоосноос хойш хоёр орны батлан хамгаалах салбарын

харилцаа амжилттай хөгжиж байгааг тэмдэглээд цаашид хоёр улсын цэргийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх талаар БНТУ-ын талтай хамтран ажиллахаа илэрхийлэв.

Тэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 2006 оноос эхлэн Бүгд Найрамдах Турк Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран "Анадолу", "Нүүдэлчин дайчид", "Эфэс" зэрэг олон улсын болон хоёр талын хамтарсан сургуулиудад оролцож

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

356,454 +1434

ЭДГЭРСЭН

535,201

НАС БАРСАН

1,641 +12

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 247,140,208

Эдгэрсэн

Нийт: 224,900,353

Нас барсан

Нийт: 5,006,081

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

6121 +105

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

169

ЭДГЭРСЭН

5832

СУРГАЛТ

ХОРООДЫН ЗАСАГ ДАРГА НАР ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Баянзүрх дүүргийн хороодын Засаг дарга нарын ЗДТГ-ын Цэргийн штабаас дунд "Цэргийн бэлтгэл"

сургалт"-ыг энэ сарын 2, 3-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтаар батлан хамгаалах бодлого, зорилт, үйл ажиллагааг танилцуулах, салбарын хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, иргэний цэргийн үр дүн биелэлтэд иргэд, байгууллага, хорооны оролцоог нэмэгдүүлж мөн төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд хүргэх хууль эрх зүйн мэдлэгийн хүрээг дээшлүүлэх зорилготой юм.



ИННОВАЦ

ЭРДЭМТДЭЭС БҮРДСЭН АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДЛАА



Тусгай зориулалтын техник турших үеийн тооцоо, зураг боловсруулах хамтарсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаан боллоо. ЗХЖШ-ын даргын 2021 оны А/525 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн засвар, үйлдвэрлэлийн материаллаг баазыг түшиглэн угсарч, үйлдвэрлэсэн жижиг булгийн байлдааны ажиллагаанд ашиглагдах тусгай тоноглол бүхий автомашинуудын туршилт-техникийн дүгнэлтийг зохион байгуулах ажлын хүрээнд хуралдсан энэхүү анхны хуралдаанд ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал

Ч.Цогтжаргал болон туршилт-техникийн дүгнэлт гаргах ажлын хэсгийн дарга, Материал техникийн газрын даргын орлогч, техникийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Төрмөнх тэргүүтэй ажлын хэсгийн төлөөлөл оролцсон юм. Ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаар уг ажлыг хэрхэн өрнүүлэх зохион байгуулалт, нөхцөл байдлын талаар хэлэлцээд ЗХЖШ, БХЭШ, ҮБХИС болон ШУТИС-ийн техникийн шинжлэх ухааны эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудаас бүрдсэн комисс байгуулан ажиллахаар боллоо.

"АЛДАР"-ЫНХАН ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТААР ...

Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн зорилготой уялдуулан "Алдар" спорт хорооноос удирдах бүрэлдэхүүнийхээ дунд заах арга зүйн цугларалт зохион байгуулагдаж байна. "Дасгалжуулалтын дэвшилтэд арга барилыг спортын төрлүүдэд нэвтрүүлэх" сэдвийн хүрээнд явагдаж буй энэ удаагийн цугларалт нь Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн зорилготой уялдуулж багш, дасгалжуулагчдын онолын мэдлэгийг тэлэх, шинэлэг хэлбэрээр дасгалжуулалтыг хийх, спортын амжилтыг ахиулах зорилгыг агуулж буй юм.



Цугларалтад Биеийн тамир, спортын улсын хорооны БЗГ-ын дарга О.Гэрэл, АШУУИС-ийн багш, Монголын спортын анагаах ухааны хөгжлийн холбооны тэргүүн Э.Түвшинбаяр, Допингийн эсрэг үндэсний төвийн их эмч н.Энхсанаа, Монголын спортын корпорацийн захирал Б.Хосбаяр нарын зочид оролцож "Биеийн тамир, спортын улсын хорооноос баримталж буй бодлого, зорилт, спорт хороодын гүйцэтгэх үүрэг, оролцоо", "Спортын бэртэл, гэмтлийг эрт оношлох, урьдчилан сэргийлэх", "Допингийн төрлийн эм бэлдмэл, түүний хор уршиг" зэрэг сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлж байна.


ЦАГ ҮЕ ҮЙЛ ЯВДАЛ

ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГААНД 120 ГАРУЙ АЛБА ХААГЧ ОРОЛЦОЖ БАЙНА



"Сүхбаатар" хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаанд ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан БХЯ, ЗХЖШ болон Зэвсэгт хүчний 011, 186, 234, 7780 дугаар анги, ОБЕГ, түүний харьяа Үндэсний аврах бригад, Давтан сургалт, сэргээн заслын төв-113, Ар тал хангалтын 115, Уул уурхайн аврах 09 дүгээр анги, Нийслэлийн болон Орхон, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар, ЗТХЯ-ны харьяа Далайн захиргааны газар, МХЕГ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ШУТИС, Хөвсгөл аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба, Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл усан зам" ХК-ийн нийт 120 гаруй алба хаагч, 50 нэгж техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна.

Зэвсэгт хүчний анги, салбаруудын алба хаагчид усны мандалд хөлөг онгоцыг усны гүнээс хөндлөн эрэг рүү татах ган татлага /тросс/-ыг холбох ажиллагаанд хөвөгч гүүрийг бэлтгэн тусгай зориулалтын нэгжид холбож татах ажиллагааг зохион байгуулж байгаа юм. Онцгой байдлын байгууллагын усчин аврагчид 12-16 м-ийн гүнд живсэн хөлөг онгоцыг ган татлагаар холбох, бэхлэх, салгах, хөшүүрэг хийх, гүн хэмжих, хөлгийг дотор, гадна талаас нь битүүмжлэх, хязгаар хөвүүр тэмдэгтийг байрлуулах 100 удаагийн шумбалтын даалгаврыг гүйцэтгэлээ.



Алба хаагчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд сахин тусгай зориулалтын техник хэрэгслийг горимын дагуу ашиглаж байна гэж Онцгой байдлын ерөнхий газраас мэдээллээ.

АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ-100

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙ АРТИЛЛЕРИЙН ТАНХИМАА ШИНЭЧИЛЖЭЭ

Удахгүй тохиох Артиллерийн цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Артиллерийн цэргийн холбооноос олон төрлийн ажил арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүний нэг томоохон ажил нь Монгол цэргийн музейтэй хамтран тус музейд байрлах Артиллерийн цэргийн



танхимд шинэчилсэн дэглэлт хийсэн явдал юм.

Энэхүү танхимд артиллерийн цэргийн үүсэл хөгжил, Монгол Улсын цэргийн түүхэнд үзүүлсэн үр нөлөө, зэвсэгт техникийн түүхчилсэн үзүүлэг зэргийг дэглэн харуулсан нь үе үеийн артиллерчдын ажил үйлсийг сурталчилсан, тэдний алдар гавьяаг хойч үеийнхэнд сурталчлан таниулсан сонирхолтой үзмэр, үзүүлэг боллоо.

АНГИ, САЛБАРТ

ГАЛ ТОГООГОО ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАЛАА

2021-2022 оны шинэ хичээлийн жилийн босгон дээр Зэвсэгт хүчний 330 дугаар анги цэргийн гал тогооныхоо бэлтгэлийн заал болон офицер гал тогоондоо бүрэн засварыг хийж дуусган ашиглалтад орууллаа. Гал тогооны нээлтийн үйл ажиллагаанд ангийн захирагч, хурандаа Н.Бат-Эрдэнэ, Захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, ахмад Б.Банзрагч болон ангийн нийт бие бүрэлдэхүүн



оролцсон юм. Тус засварын ажлыг хийж гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд ангийн захирагч, хурандаа Н.Бат-Эрдэнэ нийт бие бүрэлдэхүүнийхээ өмнөөс тусгайлан баяр хүргэж цаашдын ажил хөдөлмөрт нь өндрөөс өндөр амжилтыг хүсэв.